



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 09 сарын 17 өдөр

Дугаар 9/72

Улаанбаатар хот

Г Зочид буудал, дэн буудал, амралтын
газрын үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрөл олгох, хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 4588:2008” стандарт, “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын шаардлагыг хангасан, нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. “Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 5738:2007” стандарт, “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын шаардлагыг хангасан, хоёрдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. “Амралтын газарт тавигдах ерөнхий шаардлага MNS 6043:2019” стандарт, “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын шаардлагыг хангасан, хоёрдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид амралтын газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Овоотел ХХК-ийн “Овоотел” зочид буудлын 2020/05, Дельта Фүүдс ХХК-ын “Эвэргрин” зочид буудлын 19/204, Вайлд Резорт ХХК “Тайж” зочид буудлын 19/339, Алтаннаран трейд ХХК-ийн “247” зочид буудлын 19/351, Алтаннаран трейд ХХК-ийн “Эрхэс” зочид буудлын 19/352, Их

1150500215

цагаан даваа ХХК-ийн “Цэнгүүн” зочид буудлын 19/379, Ундецим Ундецим ХХК-ийн “Жи” зочид буудлын 19/281, Төгөл гоо ХХК-ийн “Бурхант төв” зочид буудлын 19/366, Мон Тул ХХК-ийн “Жи Ди Эл” зочид буудлын 19/301, Оасисмон ХХК-ийн “Оасисмон” дэн буудлын 19/360, Шидээт Аялгуу ХХК-ийн “Цолмон” дэн буудлын 19/324, Алтаннаран трейд ХХК-ийн “Мини” дэн буудлын 19/354, Бат-Олоц ХХК-ийн “Хүлэг” дэн буудлын 19/338, Тайванбаатар ХХК-ийн “Бодонч” амралтын газрын 19/359 тоот гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5. Зөвшөөрөл авсан аж ахуй нэгжүүдтэй гэрээ байгуулж, үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Р.Батням/-т үүрэг болгосугай.

6. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн Удирдах газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг Үйлчилгээний чанар, стандарт хариуцсан мэргэжилтэн /С.Туул/-д үүрэг болгосугай.

7. Зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжүүдээс гэрчилгээний үнийн 5,000 /таван мянга/ төгрөгийг Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батцоож/-д даалгасугай.



Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын дартын 2020 оны 09 сарын
17-ны өдрийн А/72 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

5284325 СБТ 48936 1116263502

ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2020 оны 09 дугаар сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Нэгүүн одон протерти ХХК	6595928	Овооотел	БГД-ийн, 19-р хороо, Энэбишийн өргөн чөлөө, 4-р хороолол 71
2	Дельта фүүдс ХХК	2562456	Эвэргрин	БГД-ийн, 3-р хороо, Тээвэрчдийн гудамж 6
3	Вайлд резорт ХХК	5968615	Тайж	ХУД-ийн, 8-р хороо, Жаргалантын ам
4	Алтаннаран трейд ХХК	2548542	247	БГД-ийн, 12-р хороо, Хасбаатарын гудамж 3б
5	Алтаннаран трейд ХХК	2548542	Эрхэс	БГД-ийн, 12-р хороо, Хасбаатарын гудамж За
6	Их цагаан даваа ХХК	5184649	Цэнгүүн	БЗД-ийн, 18-р хороо, Намьянжүгийн гудамж 10-3 тоот
7	Ти Си Эй ХХК	6580262	Кровн	БЗД-ийн, 18-р хороо, Намьянжүгийн гудамж 3 тоот
8	Үндецим Үндецим ХХК	5429552	Жи нүхт	ХУД-ийн, 4-р хороо, Нүхтийн ам
9	Төгөл гоо ХХК	5528658	Бурхант төв	БГД-ийн, 22-р хороо, 3-р хороолол /16090/ 61 тоот
10	Мон тул ХХК	2112752	Жи ди эл	БГД-ийн, 20-р хороо, Москвагийн гудамж 21

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2020 оны 09 сарын
17-ны өдрийн А/72 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

5284325 СБТ 2926 1118263502

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2020 оны 09 дугаар сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

Д/Д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Оасисмон ХХК	5678714	Оасисмон	БЗД-ийн, 12-р хороо, Чулуутын 1- 10 тоот
2	Шидэт аялгуу ХХК	6248853	Цолмон	СХД-ийн, 28-р хороо, Баянхошууны сансар 1-6
3	Алтаннаран трейд ХХК	2548542	Мини	БГД-ийн, 14-р хороо, 18/1 байр
4	Бат-Олоц ХХК	5427517	Хүлэг	БЗД-ийн, 19-р хороо, Цайз

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2020 оны 09 сарын
08-ны өдрийн А/70 дугаар дугаар
тушаалын гуравдугаар хавсралт

5284325 СБТ 8926 1118263502

АМРАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2020 оны 09 дугаар сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Тайванбаатар ХХК	5337011	Бодонч	СХД-ийн, 21-р хороо, Дэлгэр булгын ам 1-р гудамж, 1-5 тоот
2	Оптимум прогресс ХХК	6266096	Санзай	СБД-ийн, 19-р хороо, Санзайн 10- р хэсэг 1085 тоот

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР